

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Телевизийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрч, хадмал тайлбартай нэвтрүүлэхэд тавих шаардлага	MNS ... : 2025
Requirements for broadcasting television programs with sign language interpreters and subtitles	

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь монгол улсын сонсголын бэрхшээлтэй иргэдэд мэдээ мэдээлэл, телевизийн зорилтот нэвтрүүлгийн хүртээмжийг сайжруулан хүргэхэд оршино.

2. Хамрах хүрээ

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа телевизийн байгууллагууд уг стандартыг мөрдлөг болгоно.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах бичиг баримт, зөвлөмжүүдээс иш татсан болно.

- 3.1 ГОСТ Р 70189-2022 изображение переводчика жестового языка на экранах мониторов при интернет и телетрансляциях
- 3.2 Guidelines for Broadcasting Sign Language Interpreters During Televised Events
- 3.3 Media Interpreting Guidelines Final V.5
- 3.4 ГОСТ Р 57767-2017. Субтитры к кино- и видеопроодукции для инвалидов по слуху.
- 3.5 ГОСТ Р 57763 -2017. Скрытые субтитры для инвалидов по слуху
- 3.6 Soledad Zárate. Captioning and Subtitling for d/Deaf and Hard of Hearing Audiences

4. Нэр томъёо

4.1 Сонсголын бэрхшээлтэй иргэд: Бие дааж хэл яриа эзэмших, хэл яриагаа сонсголын замаар хөгжүүлэх чадваргүй болсон хүнийг сонсголын бэрхшээлтэй хүн гэнэ.

4.2 Амны хайрцгийн хөдөлгөөн ба уруулын хэлбэр: Ярианы дуу авиаг илэрхийлэх уруулын хөдөлгөөний элементүүдийн цогц

4.3 Дактиль хэл: Хурууны үсгийн (Цагаан толгойн үсэг) тусламжтайгаар харилцах

4.4 Хурууны үсэг: Монгол дохионы хэлний нэг бүрэлдэхүүн бөгөөд нэг гарын дохио зангаа бүр нь монгол дохионы хэлний нэг үсгийг илэрхийлнэ. Монгол дохионы хэл нь 35 үсэгтэй.

4.5 Дохионы хэл: Үг хэллэг, дүрмийн өвөрмөц бүтэцтэй, үгийн сан, утгын хоорондын хамаарлыг илэрхийлэх олон янзын арга барилтай, аман хэлээс эрс ялгаатай бие даасан систем юм.

4.6 Монгол дохионы хэл: “Монгол дохионы хэл бол монгол улсын сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй”

4.7 Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч: Монгол ярианы хэлийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлээр, монгол дохионы хэлийг сонсголтой иргэдэд аман ярианы хэлээр шууд орчуулга хийдэг монгол дохионы хэлийг зохих түвшинд эзэмшсэн мэргэжилтэн.

5. Дохионы хэлмэрчийг дэлгэцэд харуулах ерөнхий шаардлага

Харагдах байдал: Дохионы хэлмэрчийн өгүүлэмж нь сайн харагдаж байхын тулд хангалттай гэрэлтүүлэгтэй байна.

Дохионы хэлмэрчийн орон зай: Гар, мөр, нүүр, уруул, хэл гээд хэлмэрчийн бүхий л биеийн өгүүлэмж кадрт бүтэн харагдаж байх ёстой.

5.1 Телевизор, монитор, компьютерын дэлгэцэд дохионы хэлний орчуулагчийг харуулах формат

5.1.1 Дохионы хэлний хэлмэрчийн дүрсийг хүрээгүй тэгш өнцөгтөд байрлуулах бөгөөд тэгш өнцөгтийн хэмжээ нь үндсэн дэлгэцийн 25%-30% -аас багагүй байна. (Хамгийн багадаа дэлгэцийн өргөний $\frac{1}{4}$)

5.1.2 Дохионы хэлмэрчийн дүрс толгойноос бүсэлхий хүртэл харагдаж байх ёстой.

5.1.3 Дохионы хэлмэрчийг сүүдэр унагахгүй эгц урдаас харуулна.

5.1.4 Хэлмэрчийн зарим нэг дохио, зангаа нь гарын хөдөлгөөний далайц ихтэй илэрхийлэгдэх тохиолдол байх тул мөрнөөс дэлгэцийн хүрээ

хүртэл хангалттай зайтай байх ёстой бөгөөд энэ нь ойролцоогоор дохионы хэлмэрчийг үзүүлж буй дэлгэцийн 10 орчим хувь байна.

5.1.5 20 секундээс дээш хугацаагаар яриа ороогүй тохиолдолд дохионы хэлмэрчийн дүрсийг үндсэн дэлгэцээс авна.

5.1.6 Монгол дохионы хэлний хэлмэрчийн дүрс өгөх арын дэвсгэр өнгө нь зураггүй, хөдөлгөөнт дүрсгүй, тунгалаг биш (нэвт харагдахгүй), дан гэгээлэг, цайруу өнгө байна.

5.1.7 Дохионы хэлмэрч ширээний ард сууж байгаа тохиолдолд ширээний гадаргуу нь гэрэл шингээдэг, дүрс ойхгүй материалтай байна.

5.1.8 Дохионы хэлмэрч нь өөрийн арьсны өнгөнөөс ялгаатай, дан өнгөтэй хувцас өмсөнө.

6. Монгол дохионы хэлмэрчийн дүрсийг телевизор, монитор, компьютерын дэлгэцэд байршуулах.

Дохионы хэлмэрчийн дүрсийг техникийн болон тухайн дамжуулж буй дүрстэй мэдээллийн шинж төрхөөс хамаарч 2 янзаар үзүүлж болно.

6.1 Хэлмэрчийн дүрсийг үндсэн дэлгэцийн баруун доод буланд байршуулна. (Горим: Зураг дотор зураг, Picture in picture)



Зураг 1


Хэрэв энэ горимыг хэрэглэх техникийн боломжгүй бол хэлмэрчийн дүрс бага зэрэг төв хэсэг рүү байрлаж болно. Гэхдээ аль болох зах руу байрлуулна.



Зураг 2

Хэрэв баруун доод буланд тухайн сувгийн лого эсвэл тухайн нэвтрүүлэгт онцгой ач холбогдол бүхий дүрст мэдээллийг баруун доод буланд байршуулах хэрэгтэй байгаа бол дохионы хэлмэрчийн дүрсийг зүүн доод булан байршуулна.

6.2 Үндсэн дэлгэцийг зүүн тал руу 70% шилжүүлнэ. Баруун талын сул талбайд дээр доороос нь хасаж хэлмэрчийн дүрсийг тэгш өнцөгтөд үзүүлнэ. Энэ талбай нь зураггүй, хөдөлгөөнт элементгүй, хурц тод өнгөгүй байх ёстой.



Зураг 3

6.3 Монгол дохионы хэлмэрчийн дүрсийн чанар

- 6.3.1 Дохионы хэлмэрчийн дүрсийг урт, өргөнөөр нь татаж сунгахгүй.
- 6.3.2 Хэлмэрчийн дүрс нь маш сайн фокуслагдагдсан байна. Ялангуяа уруулын хөдөлгөөн, гарын дохио зангааг тод харуулахын тулд нүүр, гарын хэсгийг тод харуулах ёстой.
- 6.3.3 Дохионы хэлмэрчийн нүүр, гарын дүрсийг хангалттай тод, ямар нэгэн сүүдэр унагахгүй үзүүлэх ёстой.

7. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд кино, видео нэвтрүүлгийг хадмал тайлбартай хүргэх техникийн ерөнхий шаардлага

Энэхүү стандарт нь мэдээллийг хүртээмжтэй байлгах үүднээс сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан кино, видео нэвтрүүлгийн хадмал орчуулга хийхэд хэрэглэнэ.

7.1 Нэр томъёо

- 7.1.1 **Субтитр:** Кино, телевизийн нэвтрүүлгийн дуу авианы эх хэл, орчуулсан хувилбарыг текстээр үзүүлэх

7.1.2 Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан субтитр: Сонсголын бэрхшээлтэй иргэдэд тусгайлан зориулсан кино, телевизийн нэвтрүүлэг, дүрстэй нэвтрүүлгийн дуу авиаг бичгэн хэлбэрээр (текст) илэрхийлэх

7.2 Субтитрт тавигдах шаардлага. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан субтитрийн онцлог

7.2.1 Субтитрт дэлгэцээр дуугарч байгаа яриа, хөгжим, дуу авиа, бүрийг бичиж, илэрхийлсэн байх ёстой.

7.2.2 Субтитрийн бичвэр нь орчин цагийн Монгол хэлний зөв бичих дүрмийг баримтлах ёстой.

7.2.3 Дуу чимээ, ярианы онцлогийг зохих тайлбар, тэмдэглэгээгээр илэрхийлсэн байх ёстой.

7.2.4 Кадрт үзүүлэх хадмал текстийн мөрийн тоо хоёроос хэтрэхгүй байх ёстой.

7.2.5 Дэлгэцээр ярьж байгаа хүний яриаг энэ хэсэгт оруулах зайлшгүй шаардлагатай бол, үлдсэн өгүүлбэр нь дараагийн дүрстэй давхцахаар бол, мөн түүнчлэн тухайн өгүүлэмж нь агуулгаа бүрэн илэрхийлэх нь чухал гэж үзвэл 3 дахь мөрийг ашиглаж болно.

7.2.6 Субтитрийн текст нь дүрс халхлахгүй байх ёстой бөгөөд дэлгэцийн төвд бичигдэнэ.

7.2.7 Субтитрийг дэлгэцэнд яриатай зэрэг өгч, зэрэг авна. Дэлгэцэд өгөх хугацаа нь ярианы үргэлжлэх хугацаанаас хамаарна. Богино өгүүлбэртэй хэсэгт субтитрийн үргэлжлэх хугацаа 2 секундээс бага байж болохгүй.

7.2.8 Хадмал текстийг дэлгэцэд харуулах хугацаа нь нийт тэмдэгтийн тооноос хамаарна.

7.2.9 Тухайн дүр бүтээгч их хурдтай, үргэлжилсэн удаан ярьж байх тохиолдолд дүрийн эх яриаг хадгалан субтитрийг тухайн дүрийн эх дуутай харгалзуулан оновчтой өгөх шаардлагатай.

7.2.10 Ярианд үгээ аялгаар илэрхийлсэн бол субтитрт нэмэлт тайлбар, тэмдэглэгээгээр илэрхийлнэ.

7.2.11 Хадмал орчуулга нь монгол хэлний дүрмийн дагуу улс, газар нутаг, хотын нэрийг зөв бичих ёстой бөгөөд анхаарлын тэмдэг, цэг, таслал, цуваа цэг болон бусад тэмдэгтүүдийн хэрэглээний онцлогийг хатуу баримтална.

7.3 Техникийн шаардлага

- 7.3.1** Дэлгэц дээрх субтитр нь хоёр мөрөөс хэтрэх ёсгүй.
- 7.3.2** Хэрвээ текст ихтэй бол эхний мөрөнд үндсэн утга оруулахыг зөвлөж байна.
- 7.3.3** Субтитрийн нэг мөр нь цэг, таслал зай зэрэг тэмдэгтийг оролцуулаад 38 тэмдэгтээс хэтрэх ёсгүй.
- 7.3.4** Хоёр мөрөнд бичигдсэн субтитр нь зай, цэг, таслалыг тооцоод 76 тэмдэгтээс илүүгүй байна.
- 7.3.5** Субтитр нь кадрын доод дөрөвний нэгт байрлах бөгөөд дүрүүдийн нэр, график зургууд (газрын зураг, дүрс, улс орны нэр, мэргэжлийн нэр, тайлбар), ярьж байгаа хүний нүүр болон уруулыг халхалж болохгүй. Иймэрхүү давхцал үүсвэл субтитрийг дэлгэцийн дээд хэсэгт шилжүүлэх эсвэл 1 - 1.5 секундйн дараа өгнө. Ингээд ч титр нь дээрх хэсгийг халхалж байвал дэлгэцийн баруун, зүүн аль нэг талд дүрс халхлахгүй хэсэгт байрлуулна.
- 7.3.6** Титр нь тогтоосон талбараас хальж болохгүй, зөвхөн аюулгүй бүс дотроо байрлана. Жич: Аюулгүй бүс гэдэг нь төхөөрөмжийн дэлгэцийн нягтралаас үл хамааран текст тайрагдахгүй байх видео дэлгэцийн харагдах хэсгийг хэлнэ. 16:9-ийн форматад идэвхтэй өндрийн 90%, идэвхтэй өргөний 90% нь харин 4:3-ийн форматад идэвхтэй өргөний 67,5%, идэвхтэй өндрийн 90% -ийг аюулгүй бүс гэж тооцдог.
- 7.3.7** Титрт бичигдсэн өгүүлбэр зүйн цогц байдал өөр хэсэг, өөр кадр руу шилжиж болохгүй.
- 7.3.8** Субтитр өгөх эхлэл хугацаа нь тухайн өгүүлбэрийн эхлэлтэй давхцаж байх ёстой.
- 7.3.9** Өгүүлбэрийн нарийн төвөгшилөөс хамааран субтитрийн төгсгөл хугацаа өгүүлбэр дуусах хугацаанаас хойш байж болно.
- 7.3.10** Субтитр өгөх хугацааг дараагийн үзэгдэл, хэсэг рүү давуулж болохгүй.
- 7.3.11** Дэлгэцэд субтитр үзүүлэх хугацаа нь насанд хүрэгчдийн минутад унших дундаж хурдыг 235 үгээс хэтрүүлж болохгүй. Хүүхдийн киноны титрийг минутад 150-160 үг унших боломжтой гэдгийг тооцно. (Насанд хүрэгчид нэг минутад дунджаар 200 үг уншдаг гэсэн судалгаа байдаг.)
- 7.3.12** Хүлээж авахад ээдрээтэй субтитрийн дэлгэцэд үзүүлэх хугацааг үндсэн ярианаас арай урт хугацаагаар өгч болно.
- 7.3.13** Субтитр үзүүлэх хугацаа нь текстийн хэмжээнээс хамаарна.
- 7.3.14** Субтитрийг эх дуутай дүйцүүлж, синхрончлохын тулд текстэд засвар хийхдээ өгүүлж буй үндсэн утга агуулгад өөрчлөлт оруулахгүй.
- 7.3.15** Текстэд хэн ярьж байгааг таниулахын тулд дууны эффектийн тэмдэглэгээ, нэмэлт тайлбар элементүүд оруулсан бол ярианыхаа

үгийн тоог хасаж, субтитрийн текстийг дэлгэцэд үзүүлэх хугацааг нэмнэ.

- 7.3.16** Субтитр өгөх хугацаа 8 секундээс хэтрэхгүй байх ёстой. Хөгжмийн үзүүлбэрт хадмал тайлбар хийсэн бол дэлгэцэд үзүүлэх хугацааг 12 секунд хүртэл уртасгаж болно.
- 7.3.17** Субтитрийн текст харуулах хамгийн богино хугацаа 2 секундээс бага байж болохгүй.
- 7.3.18** Шинэ нэвтрүүлгийн субтитр үзүүлж байгааг үзэгчдэд ойлгомжтой байлгах үүднээс хадмал орчуулгын хоорондох зай нь 2 кадраас багагүй байна.
- 7.3.19** Текст бичихдээ Arial, Verdana, Helvetica үсгийн фондуудын аль нэгийг ашиглана.
- 7.3.20** Том, жижиг үсгээс бүрдсэн шрифтийн өндөр нь идэвхтэй дүрсийн мөрийн өндрийн 8 хувьтай тэнцүү байх бөгөөд 2 мөрийн өндрөөр дэлгэцэд харуулна. (double-height line)
- 7.3.21** Субтитрийн текст нь гэрэлтэй өнгөөр бичигдсэн байна. Нарийн хар хүрээтэй цагаан эсвэл бүдэг шар өнгө, саарал, цэнхэр эсвэл гэгээтэй ногоон зэрэг тод биш өнгийн үсэг хэрэглэж болно.
- 7.3.22** Субтитрт хагас тунгалаг хар өнгийн дэвсгэр ашиглахыг зөвлөдөг. Мөн хар, саарал дэвсгэр өнгөн дээр текстийг цагаанаар бичиж болно. Текстийн өнгө бүдэг цагаан байна.
- 7.3.23** Текстийн өнгө дэвсгэр өнгөнөөс ялгарахуйц тод байх ёстой.

Төгсөв